



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ГАЛШАР СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРОО**

Хэнтий аймаг, Галшар сум
Утас: 99064469, 93080918

E-mail: ardchilalgalshar@yahoo.com

2022.04.12 № 05
танай _____ -ны № _____ -Т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дах хэсэг, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу ёонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивийн тайланд дүгнэлт гаргуулахаар хүргүүлээ.

Хавсралт:

ДАРГА



Б.ЭНХТАЙВАН

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН АРДЧИЛСАН НАМААС
2022 ОНЫ ОРОН НУТГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2022.04.12

НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ /Боловсрол, Эрүүл мэндийн үйлчилгээ, Өрх гэр бүл, хүүхэд, нийгмийн хамгаалал, Аялал жуулчлал, спорт урлаг/

- 1.1. "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэ эхлүүлнэ
- 1.2. Нутгийн боловсон хүчнийг дэмжих "Оюунлаг Галшарчууд" хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.3. Сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийг шинээр бариулж ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 1.4. Чөлөөт цагаа өнгөрүүлэх, бие бялдараа хөгжүүлэх, спортоор хичээллэхэд зориулсан хүүхэд залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулна.
- 1.5. ЭМТ-ийн барилгыг шинээр бариулна
- 1.6. Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
- 1.7. Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангуулна
- 1.8. Эмч нарыг нарийн мэргэжлийн сургалтанд үе шаттай хамруулна.Шүдний кабинетийг тогтмол ажиллуулна.
- 1.9. "Эртэч Монгол-Эрүүл Монгол" аяныг сум, багийн хэмжээнд өрнүүлднэ
- 1.10. Сумын хэмжээнд гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, мэдлэг үр чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ
- 1.11. Орчин үеийн тохилог орон сууц, хаус барих санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.12. Соёлын төвийн барилгыг ашиглалтанд оруулна
- 1.13. Ардын урлагийн наадмыг зохин байгуулна.
- 1.14. Хужиртын төв, Сүмийн хадыг түшиглэн түүхэн болон байгалийн аялал жуулчлалыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлнэ.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- 2.1. Малын гаралтай түүхий эд, арьс шир боловсруулах, дайвар бүтээгдхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрүүдийг бодлогоор дэмжинэ
- 2.2. Сумын мал эмнэлгийн тасгийг зориулалтын багаж тоног төхөөрөмж, ДУК автомашинаар хангуулна.Баянбадрал багт мал угаалгын ванн шинээр бариулна.
- 2.3. Хөдөө аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэн тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч ажиллана.
- 2.4. Галшарын улаан ямааны судалгааны ажлыг үргэлжлүүлж "Үүлдэр"-ээр батлуулах асуудлыг шийдвэрлүүлэх
- 2.6. Аймаг, сумын сайн малчдыг шалгаруулах журамд бэлчээрийг хамгаалах, үсжуулах, орон нутгийн хөгжилд оруулсан бодитой хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийг тооцдог шалгуурыг тусгаж малчдын нийгмийн идэвхи оролцоог дээшлүүлнэ
- 2.7. Чинээлэг малчин" хөтөлбөрийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ
- 2.8. Малчин өрхүүдийг нар, салхины цахилгааны эх үүсвэрээр хангах асуудлыг эхлүүлнэ.

ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- 3.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулж мөрдүүлнэ
- 3.2. Сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажлыг дуусгаж орчин үеийн тохижилт бүхий дэд бүтэц хөгжсөн "Жишиг сум" болох зорилтыг хэрэгжүүлнэ.
- 3.3. Сумын төвд "Хашаандаа сайхан амьдрая", "Жорлонгоо өөрчилнэ" төсдүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.4. Иргэдийн санал санаачилга, оролцоонд тулгуурлан сумын хилийн цэсийг тодотгон баталгаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.



Handwritten notes in red ink on the right margin, including the word 'СЭЖИЛ' and other illegible characters.

- 3.5. "Орон нутгийн хөгжлийн сан" гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж үр ашгийг дээшлүүлнэ
- 3.6. Сумын хэмжээнд байгаа гол, булаг, шанд, нуур цөөрмийг хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана
- 3.7. Гадаад дотоодын эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран уналга, хурдны Галшар үүлдрийн адуу, ноолуурын чиглэлийн Галшар омгийн улаан ямааны удам зүйн судалгааг гүнзгийрүүлнэ.
- 3.8. Алслагдсан багуудад үүрэн холбооны сүлжээг шинээр бий болгоно.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- 4.1. " Эрх зүйн хөтөч" хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдмин хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулна
- 4.2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах ажлыг зохион байгуулах,
- 4.3 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдхүүний бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж гамшгийн эрсдлийг бууруулна.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАЦ МОНГОЛ / Байгаль орчин, ногоон хөгжил /

144297
46 9074082

- 5.1. Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулсан байгальд ээлтэй сум болгоно
- 5.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан " НЭГ ТЭР БҮМ МОД" хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцоно
- 5.3. "Байгальд ээлтэй малчин" шалгаруулах журмыг сумын ИТХ-аар батлуулж жил бүр шалгаруулна
- 5.4. Малчдын хамтын оролцоонд түлгүүрлэн бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх ажлыг хийнэ.
- 5.5. Олон наст, тэжээлийн ургамал тариалах иргэд, малчдын бүлгийг бодлогоор дэмжих
- 5.6. Ховор, нэн ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг дэмжин ажиллана.
- 5.7. Уул уурхайн чиглэлээр олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цөөлөх замаар " Лицензгүй сум" болох зорилтыг хэрэгжүүлж эхэлнэ
- 5.8. Рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулна

ГАЛШАР СУМЫН

АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА

Б.ЭНХТАЙВАН

